

Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн
324 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Шингэрүүлсэн хий, сайжруулсан түлш хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17100

Хөдөлмөрийн нэхцэл:

Онцгой нэхцэл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Шингэрүүлсэн хий болон сайжруулсан түлшээр хангах талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэглэгчдийн зохистой хэрэглээг дэмжих ажлыг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Шингэрүүлсэн хийн болон сайжруулсан түлшний хэрэглээг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах.
2. Агаарын чанарыг сайжруулах бусийн айл өрхүүдэд сайжруулсан түлш нийлүүлэх ажлыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэх.
3. Сайжруулсан түлшний тээвэр, агуулахын анхан шатны холбогдох тооцоо, судалгааг гаргаж, хууль тогтоомжийн хүрээнд бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
4. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2. Шингэрүүлсэн хийн болон сайжруулсан түлшний хэрэглээг нэмэгдүүлэхтэй холбоотой тогтоомж, дүрэм журам, стандартыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Шингэрүүлсэн болон сайжруулсан түлшний үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хийн хэрэглээг нэмэгдүүлэх, бохирдлын хэмжээг бууруулахад зориулж авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;	Мэдээлэл нь судалгаа, нотолгоотой бодитой байна.	Г
	2. Шингэрүүлсэн болон сайжруулсан түлш үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж байгууллагын ирүүлсэн санал, санаачилгыг дэмжих, хамтран ажиллах, үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх;	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжсэн байна.	Г, Т
	3. Шингэрүүлсэн болон сайжруулсан түлшний тооцоо судалгааг гаргах, эдийн засгийн үр ашгийг тооцох;.	Тооцоо судалгаа үнэн бодитой байна.	



	4.Хийн болон шингэрүүлсэн хийд агуулагдах химийн хорт бодисын талаар дотоодын болон олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох, иргэдийг мэдээллээр хангах;	Иргэд мэдээ, мэдээлэлтэй болсон байна.	Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах;	Эрсдэл буурсан байна.	Г
	2.Бусад албан хаагчидтай албаны хэрэгцээт мэдээллээ шуурхай солилцох;	Мэдээлэл нь судалгаа, нотолгоотой бодитой байна.	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдеж, нэгжийн үйл ажиллагаанаас гарах баримтыг архивын холбогдох хууль журмын дагуу бүрдүүлж, хадгаламжийн нэгж болон цахим сан үүсгэн архивт хүлээлгэн өгнө.	Стандарт хангагдсан байна.	Г
	4.Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх;	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г, Ш
	5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол		Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил		-хүрээлэн буй орчны шинжлэх ухаан /0521/; -хими /0531/; -химийн инженерчлэл ба боловсруулалт /0711/.
Мэргэшил		Төрийн албандаа мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.
Туршлага		Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх ур чадвар	<ul style="list-style-type: none"> - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;



	<ul style="list-style-type: none"> - хууль тогтоомжийн хүрээнд ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - бусдын санал бодлыг сонсох, хүндэтгэх; - үссэн нөхцөл байдлын зэрэг болон сөрөг үр дагаврыг тооцох санал боловсруулах; - асуудлыг эв зүйгээр шийдэх; - бусад.
Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын үзэл бодлыг сонсох; - маргаантай асуудалд хүлээцтэй, нийцтэй ханддаг байх; - бусад.
Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - төрийн албан хэрэг хөтлөлт, монгол хэлний зөв бичих, найруулга зүйн чадвартай байх; - байгууллага, хувь хүний нууцыг хадгалах; - кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

ГАЗРЫН ДАРГА, ХЭЛТСИЙН ДАРГА, АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН.

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
Байхгүй	<ul style="list-style-type: none"> - Яам, агентлагийн холбогдох албан тушаалтан, - Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан, - Төрийн болон төрийн бус байгууллага, - Иргэн хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ <i>М.Болшевик</i> , №.Болшевик 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо 22 05 11 Дугаар 324 

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДЛОТЫЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2022.05.20

Дугаар: А/42

ДАРГА:

М. Голбаяж
(Гарын үсэг)

М. Голбаяж
(Эцэг/эх/ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 05 дугаар сарын 20 -ны өдөр

